



B+HR ACADEMY



From
the People of Japan



МОНГОЛ УЛСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЯПОНЫ БОЛОН БУСАД ОЛОН УЛСЫН КОМПАНИУД, ТЭДНИЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ГУРВАН-АЛХАМ БҮХИЙ ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЗӨВЛӨН ЧИГЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Япон болон бусад олон улсын компаниуд нь өөрсдийн бизнесийн үйл ажиллагаа болон тэдний ханган нийлүүлэгчдээс хүргэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь нийгэмд ямар нөлөө үзүүлж байгааг таньж мэдэж, түүнээс гарсан сөрөг үр дагаврыг хэрхэн шийдвэрлэж буйгаа харуулах хэрэгцээ шаардлагатай тулгараад байна.

Япон Улсын Засгийн Газраас гаргахаар төлөвлөж буй “Ханган нийлүүлэлтийн сүлжээнд хүний эрхийг хүндэтгэх тухай удирдамж”-д олон улсын дүрэм, журамтай нийцүүлэн бизнесийн салбар хүний эрхийг хэрхэн хүндэтгэх тухай тусгана.

Герман, Франц болон Их Британи зэрэг олон улс орнуудад дээрх асуудлаар хэд хэдэн дүрэм журам, зохицуулалтыг гаргаад байна. Европын Холбооноос батлахаар зэхэж буй Компанийн Байгаль орчны Тогтвортой Байдлын Магадлан Шинжилгээний Захирамжид ЕХ-ны нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй томоохон компаниуд бүгд хүний эрхийн болон байгаль орчны магадлан шинжилгээ хийх шаардлагатай болохыг заасан. Албадан хөдөлмөрийн үр дүнд бий болсон аливаа бараа бүтээгдэхүүнийг АНУ-д импортлохыг түр хязгаарлах журмаар хориглоод байна.

Компаниудад үзүүлж буй дээрх шахалт нь зөвхөн бодлого эсвэл дагаж мөрдөх дүрэм журамтай холбоотойгоор бий болоогүй. Хэрэглэгчид болон хөрөнгө оруулагчдын зүгээс бизнесийн байгууллагууд нь хүүхдийн хөдөлмөр, орчин цагийн боолчлолд холбогдохгүй байх хүлээлтэй байхын сацуу дэлхий дахин дахь хариуцлагагүй бизнесийн үйл ажиллагааны асуудалд хэвлэл мэдээллийнхэн ч анхаарлаа хандуулж байна.

Өнөөгийн даяарчлагдаж буй зах зээлд, бизнесийн байгууллагууд нь нийгмийнхээ сайн сайхан, аж байдалд анхаарал тавьж буйгаа харуулж чадвал урт хугацаанд өрсөлдөхүйц чадвараараа бизнесээ тогтвортой явуулахын зэрэгцээ хууль эрх зүйн, үйл ажиллагааны, санхүүгийн болон нэр хүндийн эрсдэлээ ч сайн даван туулж чадах юм.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр нь Япон Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Япон болон бусад компаниуд, тэдний ханган нийлүүлэгчдийг өөрсдийн үйл ажиллагаанаас үүдэн гарах аливаа хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөгөө илүү таньж мэдэхэд зориулсан гурван-алхам бүхий зөвлөн чиглүүлэх үйлчилгээг үзүүлэх боломжтой болж байна. Уг төсөл нь Япон болон бусад 17 оронд: Гана, Индонез, Казакстан, Кени, Киргизстан, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Мехсик, Монгол, Мозамбик, Непал, Пакистан, Перу, Тайланд, Тунис, Турк, Украин болон Вьетнам улсад хэрэгжиж байгаа бөгөөд эдгээр улсад магадлан шинжилгээ хийх зохих үйл ажиллагааг эхлүүлж байна.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Бизнес ба хүний эрхийн төслийн мэргэжилтэн Т.Ариунаатай ariunaa.tumurtogoo@undp.org имейлээр холбогдож авна уу.

3-Алхам бүхий Хүний эрхийн магадлан шинжилгээ хийхэд зөвлөн чиглүүлэх үйлчилгээ

1

Улс орон дахь нөхцөл байдлын үнэлгээ хийх судалгаа

Төсөл хэрэгжиж буй 17 улс орон тус бүрт үйл ажиллагаа явуулж буй Япон болон бусад компаниуд, тэдний ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагаатай холбоотой гарч болзошгүй хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөө болон хүний эрхийн магадлан шинжилгээ хийх шаардлага, хүсэл эрмэлзлийг тодорхойлох зорилгоор НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс улс орон дахь нөхцөл байдлын үнэлгээ хийж байна. Дээрх судалгааг олон нийтэд танилцуулахгүй бөгөөд зөвхөн оролцогч компаниуд болон холбогдох төрийн байгууллагын хүсэлтийн дагуу судалгааг танилцуулна.

2

Хүний эрхийн магадлан шинжилгээний сургалт

Улс орон дахь хүний эрхийн нөхцөл байдлыг үнэлэх судалгаа, Япон болон бусад компаниуд, тэдний ханган нийлүүлэгч байгууллагуудын хэрэгцээ шаардлагад үндэслэн Япон болон бусад зорилтот 17 оронд хүний эрхийн магадлан шинжилгээний сургалт зохион байгуулна. Сургалтыг Япон болон Монгол хэлээр явуулах бөгөөд НҮБ-ын мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн байгууллага зохион байгуулна.

3

Хувь компаниудад зориулсан ганцаарчилсан зөвлөн чиглүүлэх үйлчилгээ

Илүү дэлгэрэнгүй ганцаарчилсан зөвлөн чиглүүлэх үйлчилгээг хувь компаниудад үзүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд Япон болон Англи хэлний орчуулагчтай явуулна. Энэхүү харилцан оролцоонд тулгуурласан, ганцаарчилсан зөвлөн чиглүүлэх үйлчилгээгээр тухайн улс оронд үйл ажиллагаа явуулж буй компаниуд нь хүний эрхэд үзүүлэх нөлөөгөө хэрхэн шийдвэрлэх тал дээр зөвлөгөө мэдээлэл авах болно.

Яагаад дээрх компаниуд Бизнес ба Хүний эрх Академид оролцох ёстой вэ?

- Дээрх 17 улсад бизнесээс хүний эрхэд үзүүлж буй хамгийн анхааруштай сөрөг нөлөөллийн талаарх сүүлийн үеийн мэдээлэл, дүн шинжилгээтэй танилцана.
- Хүний эрхийн магадлан шинжилгээг хэрхэн хийх талаарх мэргэжлийн зөвлөгөөг үнэ төлбөргүй, ганцаарчилсан хэлбэрээр авна.
- Нийгмийнхээ аж байдлыг сайн сайхан болгохыг зорихын хажуугаар олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараа улам сайжруулах боломжтой.